

**ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ,
СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН**



**Гадаадын зарим улсын хууль зүйн
их, дээд сургуулиуд дахь шүүх эрх
мэдлийн хичээлийн агуулга,
хэлбэрийн харьцуулсан судалгаа**

ЛАВЛАГАА

Шүүхийн хүний
нөөцийн газрын
захиалгаар бэлтгэв.

Улаанбаатар хот
2015 он 05 сар

“Гадаадын зарим улсын хууль зүйн их, дээд сургуулиуд дахь шүүх эрх мэдлийн хичээлийн агуулга, хэлбэрийн харьцуулсан судалгаа”¹

Тус лавлагаагаар Япон, АНУ, БНХАУ, Австри, Унгар улсын зарим хууль зүйн сургуулиуд дахь хичээлд шүүх эрх мэдлийн сэдвийг хэрхэн судалдаг, ямар хичээлийн агуулгад багтдаг талаарх мэдээллийг бэлтгэлээ.

Удиртгал

Харьцуулсан судалгаа хийх улс, хууль зүйн сургуулиудыг сонгохдоо эрх зүйн бүл болон эрх зүйн хөгжлийг харгалзав. Судалсан улсын хууль зүйн сургуулиудад “Шүүх эрх мэдлийн хичээл” гэдэгт шүүхийн тогтолцоо, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх болон харьцуулсан эрх зүйн хичээлийг ойлгох хандлагатай байна.

Түүнчлэн тус хичээлийг бакалаврын² болон магистрын сургалтын хөтөлбөрт судлах бололцоотой байна. Бакалаврын хөтөлбөр нь хууль зүйн клиник сургалт болон дадлагын ажил байдлаар боловсруулагдсан байх нь түгээмэл байна. Магистрын сургалтын хөтөлбөр нь мэргэжлийн шүүгчдэд зориулсан байдлаар боловсруулагджээ.

1. Япон улс

1.1. Нагояагийн Их сургууль

Хичээлийн нэр: Шүүх тогтолцооны үндэс

Нагояагийн Их сургуульд ордог энэхүү хичээл нь сонгох хичээл юм. Үүнийг Нагояагийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн албан ёсны 2015 оны Оюутны гарын авлага болон нэгдсэн хичээлийн цахим сүлжээнээс орчуулав.

Хичээлийн агуулга	Шүүх тогтолцооны үүрэг, ач холбогдлын талаар өөрийн орны нөхцөл байдлыг ажиглан судалж, тодорхой асуудлуудаар гүнзгийрэх. <u>Хэрэгжиж буй шүүх тогтолцооны шинэчлэлийн тухай судлан хэлэлцэх.</u>
Зорилго	1. Хууль судлалын үндэс болгож шүүх тогтолцооны бүтэц болон тэдгээрийн хариуцаж буй үүрэг, ач холбогдлын талаар ойлголтой болох. 2. Өөрийн орны шүүх тогтолцооны онцлог болон шүүх тогтолцооны шинэчлэлийн агуулга, ач холбогдлын талаар эргэцүүлэх. 3. Шүүх байгууллагын талаар судлах. Үүгээр дамжиж, нийгэмд орших хууль эрх зүйн асуудал болон түүнийг шийдвэрлэх хуулийн үүргийн талаар эргэцүүлэх.
Сурах бичиг	Одоогоор байхгүй.
Ашиглагдах эх сурвалж	Ичикава Масато. “Өнөөгийн шүүх тогтолцоо”. 4 дүгээр хэвлэл, Юухигаку. 2005 он
Дүн, үнэлгээний арга	Шүүх хуралдаанд суусан тэмдэглэл болон хичээлийн явцад тодорхой сэдвээр өгсөн тэмдэглэл.

Японы хичээлийн 1 жил нь 2 семестер буюу улиралтай байдаг. Одоо 1 улиралд орох энэхүү хичээлийн агуулгыг танилцуулая.

№	Сэдэв	Агуулга
1	Танилцуулга	Хичээлийн арга барил, ашиглагдах эх сурвалжууд, тэмдэглэл бие даалтын тухай тайлбар зэрэг. Хууль гэж юу болох талаар ойлголт, шүүхийн шийдвэрийн унших арга
2	Шүүхийн хянан шийдвэрлэх	Хуулийн 3 мэргэжлийн ажлын эрх үүргийн тухай ойлголт

¹ Тус лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа, сургалт хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам (LL.M), судлаач Ц.Мандах (LL.D), судлаач, хуульч Л.Галбаатар, туслах судлаач Б.Ариунзаяа (LL.M) нар гүйцэтгэсэн болно.

² Бакалаврын гэдэгт бакалавр буюу түүнтэй адилтгах түвшинг хамааруулав.

	ажиллагааны танилцуулга	
3	Шүүх судлал 1	Шүүх ажиллагаан дахь иргэдийн оролцооны тухай ойлголт болон дүрс бичлэг дээр тайлбарлах
4	Шүүх судлал 2	Шүүх болон шүүгчийн үүрэг
5	Шүүгчийн практик ажил, үүрэг /Зочноор 1 шүүгчийг оролцуулна/	Ажиллаж буй шүүгчийг урьж оролцуулан, бодит байдал дээрх шүүгчийн ажлын тухай ойлголттой болох
6	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо 1	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо
7	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо 2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо
8	Прокурорын тогтолцоо болон прокурор	Прокурор болон прокурорын тогтолцооны тухай ойлголт
9	Прокурорын практик ажил, үүрэг /2 зочин урина/	Одоо ажиллаж буй прокурор урьж оролцуулна. Цаазын ялын талаарх бичлэг сонсох.
10	Цаазын тогтолцоо	Өөрийн орны цаазын ялын тогтолцооны талаар хэлэлцэх
11	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо 1	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо
12	Өмгөөлөгч	Өмгөөлөгчийн ажил үүргийн тухай ойлголттой болох
13	Өмгөөлөгчийн практик ажил үүрэг /3 зочин урина/	Өмгөөлөгч урьж оролцуулна.
14	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо 2	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо

2.АНУ

2.1. Иэлийн Их сургууль

Хичээлийн нэр: Ахисан түвшний Хууль зүйн бичлэг

- Энэхүү хичээл нь 3 кредиттэй сонгох хичээл. Хичээл сонсогчдын тоо 10 хүртэл байна. Шалгалт болон бие даалт, тайлан шаардлагагүй.
- Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, шүүмж зэрэг бичиж, оюутнууд өөрсдийн бичих чадвар болон нарийн нямбай дүн шинжилгээ хийх чадвараа сайжруулах боломжтой болно. Энэ хичээлийн зорилго нь хууль эрх зүйн бичвэрийн үндсэн ур чадвараас нь илүү гойд сайн болгох юм.

Хичээлийн нэр: Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй

- Энэ хичээл нь 3 кредиттэй сонгох хичээл. Бүх оюутанд нээлттэй, оюутны тооны хязгаар байхгүй. Шалгалтаар дүгнэнэ.
- Шүүхийн процессын өмнөх үе шат, шүүхийн процесс эхлэх шат, прокурорын эрх үүрэг, шүүх процесс зэргийг нарийвчлан үзнэ.

Хичээлийн нэр: Улсын дээд шүүх

- Энэ хүчээл нь 3 кредиттэй. Шалгалт эсвэл тайлангаар дүгнэнэ. Оюутны тоо хязгаартай, дээд тал нь 30 оюутан сонгох боломжтой.
- Энэ хичээлээр Улсын дээд шүүхийн үүрэг ач холбогдол, түүний гишүүдийн зан, ёс суртахууны шалгуур байдлын тухай ойлголттой болно. Гол зорилго нь Үндсэн хуулийн эрх зүй хэрхэн үүссэн талаар гүнзгий ойлголттой болох. Өөрөөр хэлбэл хуулийг хэлбэрийн талаас илүү агуулга, үүсэл талаас нь судлана. Уншлага нь

одоогийн болон өмнөх шүүхийн шийдвэрээс сонгож хийгдэх ба дүн шинжилгээг мөн тухайн шийдвэрт хийнэ.

2.2. Бразил-АНУ-ын эрх зүй, шүүх судлалын хамтарсан хөтөлбөр³

Тус хөтөлбөр нь АНУ-ын Вашингтоны их сургуулийн Хууль зүйн коллеж дахь харьцуулсан эрх зүйн хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь Бразил болон АНУ-ын хуулийн болон шүүх эрх мэдлийн институцид онцгой анхаардаг. Бразилийн эрх зүйн болон шүүхийн тогтолцоо нь ерөнхийдөө Латин Америкийн тогтолцооны нэг хэсэгт тооцогддог бөгөөд онцын ялгаагүй байна. Мөн Бразилийн шүүгч, хуульч, судлаач, оюутнууд нь АНУ-ын хууль зүйн сургуульд Америкийн эрх зүйг суралцдаг хэдий ч Бразил болон Америкийн асуудлаар харьцуулсан судалгаа хийж чаддаггүй байна. Иймд тус хөтөлбөр нь оролцогчдыг Бразил болон АНУ-ын тогтолцоог хамтад нь бүрэн ойлгох мэдлэг, чадвар олгоход чиглэдэг.

Хөтөлбөрийн талаар:

Тус хөтөлбөр нь харьцуулсан эрх зүйн семинарын хэлбэрээр Бразилийн шүүгч, эрх зүйн мэргэжилтнүүд, судлаач, оюутнууд, шүүхийн захиргааны ажилтнуудад зориулагдсан. Хичээлийн зочин багшаар АНУ-ын Вашингтонд ажиллаж, амьдарч буй хуульч, хуулийн мэргэжилтнүүд болон тус хотод тогтмол зочилдог Бразилийн профессор, шүүгч нар оролцдог.

2.3. Невадагийн их сургуулийн “Шүүх судлал”-ын магистрын болон докторын зэргийн хөтөлбөр⁴

Шүүх судлалын магистрын зэргийн хөтөлбөр (Master of Judicial Studies-MJS) нь шүүгчдэд зориулсан мэргэшүүлэх хөтөлбөр юм. Тус хөтөлбөрийг зөвхөн тус их сургууль болон Шүүхийн үндэсний коллеж, Гэр бүлийн шүүхийн шүүгчдийн үндэсний зөвлөл эрхлэн явуулдаг. Энэ хөтөлбөр нь тус улсын 2 хөтөлбөрийн 1 нь гэдгээрээ онцлог аж. Тус хөтөлбөрийн зорилгод дараах ур чадвар олгох асуудал ордог. Үүнд:

- Эрх зүйн шүүмж, дүн шинжилгээ бичих чадварыг сайжруулах
- Үзэл бодол, дүгнэлтийг бичгээр илэрхийлэх чадвар
- Шүүхийн боловсролыг бусад хүнд олгох чадвар.

Түүнчлэн тус хөтөлбөрийн гарын авлагад⁵ дурдсанаар дараах хичээлийг заавал судлах ёстой байдаг. Үүнд:

- JS610. Шүүхийн ерөнхий харьяалал, /JS611. Шүүхийн нэмэлт харьяалал/ 4 кредит
- JS612. Захиргааны эрх зүй: Шүүх хуралдааны хэлэлцүүлэг. 4 кредит
- JS615. Шүүхийн шийдвэр бичих арга зүй. 2 кредит
- JS710. Эрх зүйн түүх, онол. 3 кредит
- JS797. Магистрын ажил. 6 кредит

Харин сонгох хичээлд дараах хичээлүүд багтдаг. Үүнд:

- JS 613 Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нотлох баримт, 2 кр
- JS 617 Нотлох баримтын тусгай анги, 2 кр
- JS 618 Шийдвэр гаргах үе шат, 2 кр
- JS 619 Эрх зүй дэх ёс зүйн асуудал, 2 кр
- JS 621 Логик ба бичгэн хэлбэрээр саналаа илэрхийлэх нь, 2 кр

³ Brazil-U.S. Legal and Judicial Studies Program <https://www.wcl.american.edu/brazil/>

⁴ Judicial studies degree program <http://www.judicialstudies.unr.edu/index.htm>

⁵ Handbook. Judicial Studies. University of Nevada, Reno 2009
http://www.judicialstudies.unr.edu/HANDBOOK_09.pdf

- JS 622 Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх нь, 2 кр
- JS 625 Маргааныг шийдвэрлэх, 2 кр
- JS 626 Шүүхийн шийдвэр, бусад баримт бичгийг бичих арга зүй: Тусгай анги, 2 кр
- JS 627 Хэргийн хөдөлгөөний үр дүнтэй удирдлага, 2 кр
- JS 629 Цогц хэргийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь, 2 кр
- JS 632 Шүүх хуралдааныг удирдан явуулах, 2 кр
- JS 633 Шүүхийн хуралдааны танхим дахь нотлох баримт, 2 кр
- JS 634 Гэр бүлийн эрх зүйн өнөөгийн асуудал, 2 кр
- JS 715 Шүүх эрх мэдэл, эрх зүй ба уран зохиол, 3 кр
- JS 718 Шүүгчийн судалгааны ажил бичих арга зүй, 3 ко
- JS 720 Харьцуулсан эрх зүй, 3 кр
- JS 725 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба Шүүх, 3 кр
- JS 730 Эрх зүй ба эдийн засаг, 3 кр
- JS 735 Эрх зүй ба Нийгмийн шинжлэх ухаан, 3 кр
- JS 740 Эрх зүй ба эмнэлгийн эрх зүй, 3 кр
- JS 745 Шүүх дэх нээлттэй байдлын бодлого, 3 кр
- JS 750 Кримнологи: Хууль сахиулах, Хариуцлага, 3 кр
- JS 760 Хэл шинжлэл ба шүүхийн процесс, 3 кр

2.4. АНУ-ын Дүүхийн Их сургуулийн “Шүүх судлалын магистрын зэргийн хөтөлбөр”⁶

Тус хөтөлбөр нь 22 кредитээс бүрдэх бөгөөд магистрын ажил бичих, тодорхой судалгаа хийх замаар суралцуулдаг. Тус хөтөлбөр нь зуны сургалт хэлбэртэй. Шүүгч болох сонирхолтой судлаач, мэргэжилтнүүд болон мэдлэг, ур чадвараа сайжруулах хүсэлтэй шүүгчдэд зориулагдсан хөтөлбөр тул сэдэв нь уян хатан бөгөөд жил бүр шинэчлэгдэнэ.

3. БНХАУ⁷

1. “Үндсэн хуулийн эрх зүй” сэдэвт хичээл (Constitutional Law /2 кредит/ заавал үзэх хичээл)

Үндсэн хуулийн эрх зүй хичээлээр нийт 4 цагийн хичээлээр орон нутгийн өөрөө удирдах ёс, ардын шүүх болон ардын прокурорын тухай агуулгыг заадаг байна.

2. “Гадаад улсын эрх зүйн тогтолцоо” сэдэвт хичээл (Constitutional Law /2 кредит/ сонгон суралцах хичээл)

“Гадаад улсын эрх зүйн тогтолцоо” сэдэвт хичээлээр эрх зүйн хөгжил, эртний Грек, Бабилон, Ром, Дундад зууны Ром-Герман, Англо-Саксон, Шариатын хууль зэргийг түүхэн хөгжилөөс нь эхэлж заадаг ба орчин цагийн Англо-Саксон, Ром-Германы эрх зүйн тогтолцоо, түүхэн хөгжил, зарим холбогдох улсын эрх зүйн систем, тогтолцоог танилцуулж заахдаа тухайн улсын шүүхийн тогтолцоог Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд товч танилцуулдаг байна.

3. “Харьцуулсан Үндсэн хуулийн эрх зүй” сэдэвт хичээл (Comparative constitutional Law /2 кредит/ сонгон суралцах хичээл)

⁶ <https://law.duke.edu/judicialstudies/degree/curriculum/>

⁷ БНХАУ-д ойролцоогоор 510 гаруй хууль, эрх зүйн мэрэгжлийн ангитай их, дээд сургууль байдаг. Түүвэр байдлаар БНХАУ-ын 10 гаруй сургуулийн хичээлийн хөтөлбөртэй танилцаж, судалсан болно.

Үндсэн хуулийн эрх зүйг суралцсан оюутнуудад Үндсэн хуулийн суурь мэдлэг дээр нь тулгуурлаж барууны орны Үндсэн хууль, хүний эрх, төрийн байгуулал, төрийн байгууллага, нам эвслийн тогтолцоог заадаг байна.

4. “Гадаад улсын захиргааны эрх зүй” сэдэвт хичээл (Administrative Laws of Major Countries 2/кредит/ сонгон суралцах хичээл)

Одоогийн гол хэдэн улсуудын захиргааны байгууллагын тогтолцоо, захиргааны эрх зүй болон онол зэргийг зааж танилцуулдаг.

5. Бусад

Зарим их сургуулийн хичээлийн хөтөлбөрт сонгон суралцах хичээлд зарим гадаад орны эрх зүйн хичээлийг оруулсан байдаг. Тухайлбал, “Япон улсын Үндсэн хуулийн эрх зүй” сэдэвт хичээлд Үндсэн хуулийн хүрээн дэх эрх мэдлийн хуваарилалт, тэдгээрийн эрх, үүрэг зэргийг заадаг. (The Constitution of Japan /2 кредит/ сонгон суралцах хичээл)

4. Австрали улс⁸

Австрали Улсад 27 хуулийн их сургууль байдаг бөгөөд эдгээрээс дараах их сургуулиуд шүүхийн сэдэвтэй хичээлүүд заадаг байна.⁹ Үүнд:

- 1) Австралийн тэргүүлэх хуулийн их сургууль бол Мельбурны Их Сургууль (University of Melbourne) бөгөөд энд бакалаврын зэрэг олгох хөтөлбөр байдаггүй. Харин хуулийн магистрын зэрэг олгох 2015 оны хичээлийн хөтөлбөрт “Judicial Power in Australia” (Австрали улсын Шүүх эрх мэдэл) гэсэн сэдэвтэй хичээл ордог байна. Энэ хичээл нь заавал үзэх хичээл биш. Харин сонгон судлах хичээлийн төрөлд хамаарна. Тус хичээлийг сонгохын тулд Үндсэн хуулийн эрх зүйн хичээлийг өмнө нь сонгож судалсан байх шаардлагыг тавьдаг. Энэ хичээлээр шүүхийн тогтолцоо, шүүхийн болон шүүхийн бус эрх мэдлийн ялгаа, муж улсын шүүх болон холбооны шүүхийн уялдаа холбоо, Дээд шүүхийн шийдвэр зэргийг судална.
- 2) Австралийн Үндэсний Их Сургууль (Australian National University)-ийн хуулийн магистрын зэрэг олгох хөтөлбөрт Австралийн Дээд Шүүх (The High Court of Australia) болон Холбооны шүүх ажиллагаа (Federal Litigation) зэрэг хичээлүүдийг сонгон судалж болдог байна.
- 3) Монашийн Их Сургууль (Monash University)-ийн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт Шүүхийн ажиллагаа болон хэрэг, маргааныг шийдвэрлэх (Litigation and dispute resolution) гэсэн заавал үзэх хичээл байна.
- 4) Аделаидын Их Сургууль (University of Adelaide)-ийн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт Хэрэг, маргаан шийдвэрлэлт болон ёс зүй (Dispute resolution and ethics) сэдэвт заавал судлах хичээл байна.

5. Унгар улс

Унгар Улсад 4 хуулийн их сургууль байдаг бөгөөд эдгээрээс Төв Европын Их Сургуулийн мэдээллийг судлав. Төв Европын Их Сургууль (Central European University)-д бакалаврын зэрэг олгох хөтөлбөр байдаггүй. Харин хуулийн магистрын зэрэг олгох хөтөлбөрт “Courts in Dialogue” (Шүүхийн харилцан яриа) гэсэн сэдэвтэй хичээлийг сонгон судлах ба энэ хичээлийг үзэхийн тулд Европын Холбооны Үндсэн хуулийг өмнө нь судлан үзсэн байх шаардлагатай. Энэ хичээлээр Европын хүний эрхийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэрүүдийг судална.

⁸ Австрали Улсад 27 хуулийн их сургууль байдаг бөгөөд энэ судалгааг гаргахад бакалавр болон магистрын зэрэг олгох хөтөлбөрийн дагуу заадаг хичээлүүдийг судалсан болно.

⁹ Хичээлийн талаарх мэдээлэл олдох боломжтой байсан их сургуулийг судалсан болно.